



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/257

Мөрөн сум

Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл зочлох жил болгон зарласантай холбогдуулан зохион байгуулсан “Хөх сувд 2023” мөсний баярын арга хэмжээний зардлын жагсаалт баталсан аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/72 дугаар захирамжийн хавсралтын “Тогтвортой аялал жуулчлал төслөөс” санхүүжих баганад, бичилт болон тооцооны алдаа түүнтэй адилтгаж болохоор өөр бусад илэрхий алдааг залруулах зорилгоор дараах байдлаар өөрчлөлт оруулсугай. Үүнд:


А. Жагсаалтын 1.Бэлтгэл зохион байгуулалт, дотоод ажил хариуцсан хэсгийн 3 дугаарт тусгагдсан “Хог хаягдлын чиглэлээр хамтран ажиллах зардал /Эко дэвшил ТББ/” 1,500.000 (Нэг сая таван зуун мянга) төгрөг, жагсаалтын 5 дугаарт тусгагдсан “Хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны зардал” 1,500.000 (Нэг сая таван зуун мянга) төгрөг гэснийг тус тус хасаж, жагсаалтын 6.Мөсөн урлан бүтээх хэсгийн 8 дугаарт тусгагдсан “Мөс гаргах хүмүүсийн хоол, шатахуун, түлээний зардал /ХХҮГ, БОАЖГ, бусад албан газрууд/-ын зарцуулах нийт төсөв болон санхүүжих дүнг 2,000.000 (Хоёр сая) төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

Б.Тогтвортой аялал жуулчлал төслийн санхүүжилтийн шаардлагын дагуу 1.000,000 (нэг сая) төгрөгийг “Аялал жуулчлалд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх сургалт мэдээлэл”-ийн арга хэмжээнд зарцуулсугай.

2. Төсвийг өөрчлөлтийн дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010165